

ГАЗАР ДЭЛХИЙН ЗУРАГ ЗҮЙН БҮТЭЭЛҮҮД БОЛОН МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ЗУРАГЛАЛЫН ОЙЛГОЛТ

С.Бадрал

Манай дэлхийн хамгийн эртний газрын зураг зүйн дурсгал болох шавраар хийсэн газрын рельеф зураг эртний Вавилоны археологийн олдвороос гарсан бөгөөд эртний Грекийн түүхч Геродот бээр Евразийн Их газар, далай тэнгис, овог аймгуудын талаар тэмдэглэн үлдээсэн бол эрдэмтэн Эрастосфен нь дэлхийн газарзүйн тогтоцыг математик тооцоололд ашиглан судалсан байдаг. Мөн Ромын эзэнт гүрний үед Газар дундын тэнгис орчмын болон Европ, Ойрхи Дорнодын улс орны газрын зургийг үйлдэж цэрэг улс төр, худалдаа, зам харилцаанд ашиглаж байв. Араб, Перс нь эртний Шумер, Вавильон, Ассирын соёл иргэншилд суурилсан өв дээр тул газрын зураг зүйн өв ихтэй.

Монголын өнгөрсөн үеийн түүхийн өв дурсгал, урлаг соёл, ёс заншил, зан үйл, шүтлэг бишрэл, мал маллагаа зэрэг нь үе үеийн эрдэмтэн мэргэд, судлаачдын анхаарлыг татаж ном бүтээлд нь ямар нэг хэмжээнд тусгагдсаар ирэв. Энэ бүгдээс Монгол зургийн байгалийн сэдэвт хамаарах боловч түүх болоод цаг үеийн тусгал болсон газар нутгийн зураг зүйн дурсгалууд гадаад, дотоодын эрдэмтдийн судалгааны эргэлтэд орж 1914 оноос цөөнгүй ном бүтээл хэвлэгдэх болсон нь сайшаалтай. Монгол орны хадны зургууд, үлгэр домгийн балар эртний сэтгэлгээнд буй “Сүн далайг шалбааг байхад, Сүмбэр уулыг дов байхад” гэсэн зүйрлэл бидний судалгааг цаг хугацааны их орон зайд хүргэнэ...

“Монгол туургатны өвөг дээдэс Хүннү нар лавтайяа тэр цагт газрынхаа зургийг үйлддэг байсан” гэж доктор Ц.Шагдарсүрэн (2001.15) Хятад сурвалжид тэмдэглэснийг дурьдаж өгүүлснээс харахад нүүдэлч дайчин бидний өвөг дээдэс Цагаан хэрэмийн өмнөх Хятадуудтай нэгэн үед нутаг орныхоо газрын зургийг бүтээн чандлан нууцалж бэлчээр сонгож, нүүдлийн зам мөр, цэрэг хөдөлгөх, газар нутаг эзэмших дайснаа дарах зэрэг олон талт үйлд ашиглаж бодлогоо шингээж байжээ. Ноён уулын булшнаас олдсон Хүннү ширдэгний (туурган) хээ чимэглэлд газрын зургийн тэмдэглэгээнд байдаг нуур гол усны эргүүлэг зураас, мод ургамал, хил хязгаарын утга дүрслэл, ширдэгний хөвөөгөөр овог аймгуудын тамга болон онго шүтээн амьтдыг давтамж болгон зохиомжилсон байгаа нь сонирхол татна. Хүннү гүрний Модун шаньюй “Газар бол улс оршин тогтнохын үндэс” хэмээх үзэл номлолыг нүүдэлч малчдын төрийн бодлогод гүн шингээж үлдээсэн нь дараа дараалан мандсан төрт улсуудад ёс мэт залгамжлан өвлөгдөж иржээ. XIII зууны эхээр байгуулагдсан Их Монголын эзэнт гүрэн хийгээд Чингис хаан, түүний залгамжлагчид ч мөн л ургахаас шингэхүй хүртэлх уудам орон зайг эзэгнэсэн Дорно, Өрнө дахины их бага улс түмнийг эрхэндээ хураасан нь Хүннүгийн шаньюй нарын гэрээс, бодлогыг гүйцэлдүүлсэн мэт байдаг. Харь газар аян дайн, элч, худалдаа жуулчлалаар яваа монгол хүмүүсийн дотор тухайн орны газар нутгийн зураглал, хүн амын тоо, эд баялгийн бүртгэл хийх нууц мэдээлэл цуглуулагчид, сонирхогч хүмүүс нэлээд байсан буй. Миний бие оюутан байх цагаасаа Их Монголын эзэнт гүрэн улс буюу “Mongol empire”-ийн байлдан дагуулал, эрхшээлдээ хураасан газар нутгийн зургууд, хамрах хүрээг харуулсан зурагтай ном хэвлэлийг цуглуулж, заримыг нь канон, гэрэл зургаар хадгалж ирсэн билээ. Дэлхийн олон оронд хэвлэгдсэн

С.Бадрал

Монгол Улсын Соёл Урлагийн их сургууль
davana_82@yahoo.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

номын тэдгээр зургууд нь түүхэнд урьд хожид гараагүй Евразийн эзэнт гүрний ер бусын оюун санааны өргөн цар хүрээ, цэрэг армийн хүч чадал, ил далдын ид шидэт увдисыг ч мэдэрч байдаг. Хубилай хааны үед Монголын эзэнт гүрэн улсад 17 жил алба хашиж, хөндлөн гулд аялаж явсан Итали хүмүүн Марко Пологийн “Жуулчлалын тэмдэглэл” гарснаас хойш Европын хаад далайгаар Дорно зүгийн сэтгэлд багтамгүй их баялагтай орнууд руу хүрэх дөт аюулгүй замыг олох гэж өрсөлдөж улмаар Өмнөд, Умард Америк, Австрали тивүүд, Номхон далайн олон их бага арлуудыг нээж Голланд, Их Британи, Испани, Португали, Франц зэрэг улсуудад ихээхэн эзэмшил колони газартай, үлэмж их хөрөнгө төвлөрүүлж түүгээрээ олон хот, орд шилтгээн босгож, гар урлал хийгээд урлагийг ивээн тэтгэж хөгжүүлсэн нь гайхалтай. Италийн сэргэн мандалтын суу билигт зураач Леонардо Да Винчи бээр төрөлх нутгийнхаа газрын зургийг зурж газарзүйн шинжлэх ухаанд хувь нэмэрээ оруулсан нь өнөө үнэт өв болов. Чухам энэ л үеэс Сэргэн мандалтын үр шимийг хүртсэн Итали хийгээд Испани, Голланд, Их Британид бүс нутаг, дэлхийн газрын зургийг зохион зурж хэвлэх, газар зүйн хэмжил зүй, зураг зүйн багаж зэмсэг, дуран авайг ч бүтээн хэрэглэж, агаарын бөмбөлөг ашиглах болсон нь газрын зургийг үйлдэн судлах дараа дараагийн ололт дэвшлийн үндэс болсон билээ.

Их Монголын эзэнт гүрний Өрнөд хязгаараас өндийсөн Оросын Москвагийн вант улс нь баруун Сэвэрийн тайгыг хөндлөн гулд туулж томоохон гол мөрнүүдийг өгсөж уруудан гаталсаар Буриад монгол, Баргужин орон, Алс Дорнод, Номхон далайн эрэг хүртэл тэлж өргөжив. Хянган уулсын зүүн хойт нутгаас XVII зууны эхээр мандсан Манж Чин гүрэн нь тэр эрчиндээ Хятадыг сөгтгөж Өвөрлөгч, Халх, Зүүн гар хэмээн хуваагдан өөр зуураа тэмцэлдэх Монголчуудад арга эв, сүр хүчийг үзүүлэн газар нутагтай нь харъяалж Чингис хааны төрийн бодлогыг зээлдэж газар эзэмшлээ тэлж, хүчирхэг баян гүрэн болов. Европын далайд ноёрхсон колони эзэмшигч орнуудын газар зүйн нээлтийн үр дүнд олж авсан гадаад далай тэнгис, эх газар, алслагдсан шинэ тивүүд, том жижиг арлуудын зураглал бүхий дэлхийн бөмбөрцгийн зургийг алдаа мадагтай, үнэн зөвд ойртуулж гаргасан газрын зургуудаас суралцсан Оросууд ч XIX зууны сүүлч XX зууны эхэн болоход байгалийн шинжлэх ухааны салбарт дэлхийд тэргүүлж Төв Ази болон Умард Зүүн хойт Азид удаа дараалан газарзүйн аялагчдыг явуулж байснаас харагдана. Манж Чин гүрэн, Солонгос, Япон улсууд нь дэлхийн бөмбөрцгийн газрын зурагтай далайн хүчирхэг гүрнүүд болох Голланд, Англи, Португалууд, хожуу Америк, Францаар дамжуулан Өрнийн улс орнуудын газар зүйн нээлтүүдтэй танилцжээ. Хятад, Солонгос, Япон нь дэлхийн газрын зургийн өөрийн гэсэн ойлголт, уламжлалт зураглалтай үндэстнүүд билээ. Юань Мин, Манж гүрнүүдийн үед умард хил болох Цагаан хэрэмийн дагуух бүс нутгийг харуулсан өнгө будагтай монгол, хятад, манж бичээстэй ховор зургууд нэлээд байдаг. Мөн Манж гүрний үед бүтээгдсэн хотын газрын зургууд ч нэлээд байхыг ном хэвлэлээс үзэж ажиглаж явлаа. Мөн XVIII-XIX зуунд бүтээгдсэн “Утай таван уул”-ын модон барын том зургийг харахад яг л газрын зураг шиг байдаг. XVII-XIX зууны Солонгос, Японы уулын оройгоос далайн эрэг, хойг, булан тохойн тогтоцыг зурсан нь хүрээлэн буй орчноо танин мэдэх гэсэн хүсэл тэмүүлэл болоод төрөлх хойг, арал хошуу нутаг, томоохон хот, тосгод, далайн боомтыг орлуулж тэнгэрээс харсан мэт нарийн тодорхой дүрсэлсэн зургууд тэдний хэмжил зүйн зураглал, мэдлэгийг харуулна. Ялангуяа Солонгос нь Хятад, Япон гэсэн эх газар, далайн хүчирхэг хоёр улсын дунд оршдог тул газрын зургаа их л нарийн бодлоготой зурж байсан.

Солонгос, Япон нь XVII-XIX зуунд Өрнө дахины далайн аялагчдаар дамжиж ирсэн дэлхийн газрын зургийн ерөнхий байдал, шинэ мэдээлэл ойлголтыг баттай авсан нь XVIII зууны сүүлч үеэс эхтэй байдаг. Солонгос, Японд модон бараар хар бэх, өнгөт бараар нугалбар, шилийг нь утсаар үдсэн зурагт номуудыг хэвлэн гаргасны дотор далайн хөвөө орчмын нутаг, Хаката булан, Нагасаки зэрэг хотуудыг дээрээс харж зурсан газрын зургууд нэлээд бий. Ер нь XVIII зууны сүүлээс Манж, Солонгос, Япон улс нь газрын зурагтаа далайн эргийн боомт зогсоол, хот суурингуудыг нарийн тодорхой зурж, ханз үсгээр тэмдэглэдэг байсан нь тогтсон ёс болж дотоод, гадаадын усан онгоцоор тээвэрлэх ачаа эргэлт, харилцаа

холбоо, ирэх буцах зорчигчид болон орох гарах эд таваар, харийн үзэл сурталд хяналт тавих зэрэг цаг үеийн олон шаардлагаас урган гарсан асуудлуудтай холбогдоно. Японы зарим газрын зураг дээр далайн эргийг дээрээс нь харсан мөртөө усанд хөвж яваа далбаат завь онгоцуудыг байгалийн бодит зурагт зурдагтай адил зурж, усыг нь хөх, тариан талбайг шар, хот тосгод, зам харилцааг улаан, нутгийн заагийг хар зураасаар тэмдэглэсэн байдаг. Мөн газрын зай завсар ханз үсгээр зайгүй бичсэн нь зургаасаа илүү жин эзэлнэ. Японы зураачид орон нутгийн болон дэлхийн газрын зургийг зурахдаа нарийн нямбай хандахын зэрэгцээ хийсвэр хэтрүүлэл ашиглан зохицсон өнгө тавьж, зураасаар чөлөөтэй татаж таталган бичгээр онгодтой бичиж байсныг харж болно. Газрын зураг нь бүс нутаг, далайн эргийн байгалийн үзэмж тогтоц, язгууртан газрын эзэд, эрх мэдэлтнүүдийн эзэмшил, улс орон, дэлхийн бөмбөрцгийн хуурай газар, далайн мандал, эх дэлхийнхээ гоо үзэсгэлэнг магтан дуулах гэсэн үе үеийн хүсэл мөрөөдөлт сэтгэлийг зураачид гярхай хараа, мэдлэг оюун, ур чадвараараа илэрхийлэн зуржээ.

Монголчуудад газрын зургийн эртний сурвалж мэдээлэл цөөнгүй байх боловч Хань улсын газрын зурагт Цагаан хэрэмийн орчим, Их говийн өмнөд зах Ордос зэрэг өмнөд Хүннүгийн нутаг цухас боловч тэмдэглэгдэж үлдсэн байдаг. Монголын эзэнт гүрний Иль хаант улсын түүхч Рашид ад дини “Судрын чуулган”-д хавсралт болгон эзэнт гүрний нутаг дэвсгэр, хотууд, зам харилцааны зураглалыг тэмдэглэн эмхтгэсэн гэдэг ч тэрхүү дурсгал хаа нэгтээ хадгалагдаж байдаг буй за. Юань гүрний үед мөн гүрэн улсынхаа газрын зургийг үйлдэн модон бараар хэвлэсэн нугалбар, номууд гаргаж байснаас манай үед хүрч иржээ. Юань улсын газар нутаг, зах хязгаар, далай тэнгис, Монголын хээр тал болон Бага Азийн газар орныг хүртэл тэмдэглэсэн өнгө оруулан зурсан нууцад хамаарах зургууд цөөнгүй байсан нь 1368 онд Монголчууд эзэн хаан, төрийн тамгаа аваад өмнөд орныг орхин Цагаан хэрэмийн ард гарах үеийн үймээнээр босогчид болон хятад, солонгос түшмэдийн гараар дамжин Хаан балгасаас гарч хуулбарлагдаж зураг зүйн ховор мэдээллийн хамт Японд хүрсэн хоёр ч зураг бий аж.

“Монголчуудын ноёрхол анх удаа олон улс түмнийг хамарсан нийгэм, хил хязгааргүй соёл бий болгосныг энэ газрын зураг мөн илтгэж байна. Тус газрын зураг бол дэлхийн жирийн нэгэн газрын зураг төдий бус, харин тэрхүү эрин үеийн үзэл санааны гэрээслэл юм” (Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. х-336) гэсэн нь бидэнд ихийг бодогдуулна.

XVII-XX зууны үеийн Монголын хошуу нутгийн газрын зурагт дэвсгэр хүрээг нь тойруулан зурахдаа уул толгодыг гадагш нь хандуулан зурж дүрсэлсэн нь нутгийнхаа эргэн тойрон бүхий л газрыг бүрэн гүйцэд харуулах гэсэн зарим зураачдын онцлог шийдэл байв. Хонь, үхэр, адуу малын арьс ширийг дэлгэн тавьсан мэт цаас, даавуун дээрх нутгийн газрын зургууд нутаг нутгийн байгаль, бэлчээр, мод ургамал, хангай говь, тал хээрийн бүсчлэл, сүм хийд, суварга шүтээн, нас нөгчигсдийг хөдөөлүүлэх газар, худаг болон рашаан булаг, зам жим, уулын овооны хоорондын зай шугам шулуун, огтлолцол, хилийн зааг зураас, аюулаас хамгаалсан хаалт цээр засал зэрэг олон давхар мэдээллийг агуулсан байдаг. Нутаг хошууны газрын байрлал, хэмжээ харьцаанаас шалтгаалж зургууд нь мал амьтны арьс, эд эрхтэн мэт, нисэж буй шувуу, тэмээний буйл, аяны богц, домбо сав, дун, гурвалжин, гонзгой, тал саран зэрэг янз бүрийн хэлбэр дүрсийг харуулдаг. Газрын шинжийн сударт “... ер газрыг шинжихдээ арц уугиулж гэдэргэлэн хэвтээд ажиглана. Арцны утаа дээш суунаглан зүүн өмнө зүг чиглэвээс сайн. Хойноо, зүүн талдаа уултай, голын ус зүүнээр урсаж баруун тийш чиглэн хойгуур урсвал сайн” хэмээн өгүүлдэг. Манай Монголчууд Дундад зууны үеэс Түвэдийн шашны ном, урлаг, зан үйлд сүжирч орсны үрээр Цастын орны газрын зургийн арга ухаанаас мөн суралцсан нь газрын шинжийн зурагт судруудаас харагдана. Уул толгодын оройг дөрвөн зүгт хандуулан тойрог үүсгэн зурах нь хүмүний газарт гэдэргэлэн хэвтээд тэнгэр газрыг нэгтгэсэн мэт өөрийгөө ертөнцийн төв цэг хэмээн сэтгэн зурж байсан нь Дорно дахины уламжлалт ойлголт юм. Ийм байдлаар харсан зургууд XVII зууны сүүлч үеийн Японы орон нутгийн газрын зурагт ч бий. Монгол хошуудын газрын зургийн дэг дүрслэл нь уул хад, гол мөрөн, нуур цөөрөм, ой мод хийгээд хүмүн амьтны донж, үйл

хөдлөлийг үндэсний уламжлалт зураг болон газрын шинжийн зурагт судар, там бирдийн зурагт судар, зурхайн зургууд, газрын цээр дарах, лус савдагийг аргадах засал тахилгын зургууд, үйчүүрийн зураглал, зохиомжийн онцлог хийгээд зураачийн сургууль, мэдлэг ойлголт, ур чадварын түвшинтэй салшгүй холбоотой. Тиймээс хошуу нутгийнхаа байдлыг зурсан газрын зургийг монгол зургийн өв, ардын болон шашны сэдэвт модон бар, таталбар зургуудыг зурах, бүтээх, илэрхийлэх арга барил, утга зүйрлэл бэлгэдэлтэй холбож үзэх нь зүй. Газрын сайн муу бэлгэ шинж, байгаль дэлхийгээ амьтай махбодтой гэх сүжиг бишрэл, хайрлан дээдлэх ариун нигүүлсэнгүй сэтгэл, газар ус нь эзэн лус савдагтай, хөрсөн дээрх мод, ургамлын шим, газар доорх эрдэс эрдэнэ, хүмүн хийгээд мал амьтны өсөн үржихүйн ашиг шим, амьдрал тэтгэх хүчин, од эрхэсийн нөлөөлөл зэрэг нь Монголын хошуу нутгийн газрын зурагт ёгтлол зүйрлэл, бэлгэдэл анхааруулга дохио ямар нэгэн хэмжээгээр ил далд хэлбэрээр шингэсэн байгааг харж, уншиж болно. Уул толгодын орой хүрээг ногоон, хөх, бор, шаргал, ухаа ягаан өнгөөр, түүний дотуур дагнааслах дулаан өнгө, гол мөрний усыг дан хөх, цэнхэрээр, мөн бурантаг томох, гэзэг сүлжих мэт, хөх ухны сахал, сэтэртэй хөх буурал морины дэл адил хөхөөр зурааслан зурж, нуур цөөрмийг мөн хөх цэнхэр өнгөөр гадаад их далай мэт дундаасаа оргилж буй тэгш дүүрэн заяа буянтайн шинж байдлаар илэрхийлж давалгаа долгио цалгиж мөн л хөх зураасаар зурж тодруулан гаргаж байв. Алтайн Урианхайн газрын зурагт Алтайн мөнх цаст оргилыг цагаанаар тэмдэглэсэн нь бий. Гол усыг хөх зураасаар сүлжих, давалгаа үүсгэн зурдаг арга нь бүр IX зууны Уйгурын ханын зураг, XIV зууны эхэн үед Иран дахь Монголын Иль хаадын номын зурагт байдаг нь эртний уламжлалт дэг дүрслэл юм. Хятад, Түвэд, Солонгос, Японы газрын зургийн модон барын дардаст нуур, далай тэнгисийн усыг мөн л үргэлж мөнхийн давалгаалах хөдөлгөөнтэй гэдгийг нь тодруулж зураасаар гаргасан байдаг. Ер нь Монголчууд болон Дорно дахины улс түмний уран зургийг зураасаар амилуулж, өнгийг таван махбодийн үүднээс их л учир утгатай тавина. Зураас нь дотроо татлаган, хөдөлгөөнтэй, усархаг, тойруу угалзрах, эрч хүчтэй, уян зөөлөн, өргөн бүдүүн, хар, хөх, бор бэхээр гээд үүрэг зориулалтаараа өөр өөр байна. Тиймээс зураасны ач холбогдол газрын зурагт онцгой үүрэгтэй байна. Хошуу нутгийн газрын зургуудыг харьцуулан шинжиж байхад уулс, ухаа гүвээ толгод, хадан цохио асга чулуу, гол булгийн усны урсгалын зураглал нь лам нарын маань уншлага, хөгжмийн ая дангийн тэмдэглэлгээний долгиолох зураасны хэмнэл хөдөлгөөн, зуны халуунд усруу цувж яваа тэмээн сүргийн бөхийг санагдуулах нь зэрэглээ, агаарын урсгал салхины чимээ анир хийгээд малчин хүмүүний нутаг усаа хайрлах сэтгэлийн дууг шингээсэн мэт гэх сэтгэгдэл төрүүлнэ. ХБНГУ-ын Берлиний түүхийн музейд буй Өвөрмонголын Зостын чуулганы Ширээт Хүрээний газрын зурагт голын усыг хөх эрээн эх могой мэт, уулын сугаас ундран урсах булаг рашааныг зулзаган могойнууд эхийнхээ араас зүүгдэх мэт дүрсэлсэн нь зураачийн хийсвэр зүйрлэл, лусын тухай сүжиг ихтэй байсныг илтгэнэ. Мөн бурханы ганзай зурагт буй эрхин, дэлгэсэн хадган чимэг, тэмээ малын хөдөлгөөн нь монгол газрын зургийн уул толгодын хүрээлбэр таталган зураг мэт харагдана. Газрын зурагт уул толгод, гол ус нь үндсэн зураглал болж газрын товгор гүдгэр, судал нь нутгийн онцлог гэдгийг харуулна.

Ардын богино дуунууд, “Хүрэн толгойн сүүдэр”, “Шалзат баахан шарга”, “Шар тал”, “Зээргэнтийн шил” зэрэг олон уртын дуунд нутгаа магтан дуулсан нь малчин хүмүүний сэтгэл, мэдлэг шингэсэн нь гайхалтай. Тиймээс нутгийн газрын зургийн зураглал дүрслэлийг монгол хүмүүний сэтгэл зүй, урлаг, зан үйлээс салгах аргагүй. Хошуу нутгийн зургийг муутуу цаас, европ цаас, цардсан цардаагүй цагаан даавуу, илэг, хөх цагаан хадган дээр бийр, хар бэх, усан шороон будгаар зурж эхлэх, дуусгахдаа билигт сайн өдөр гараг, цагийг сонгож байсан нь ургийн бичгийг эхлэн бичиж хөтлөх зан үйлтэй төстэй байсан болов уу? Зургийг нутгаа сайн мэдэх зураач, лам нар зурж, захиалагч ноёд дээдэс үзэж зөвлөж хянаад бичээч нараас жил мэнгэ нь таарсаныг нь сонгож газрын нэрс, зам харилцаа, ямар хошууны зураг болох, хэдэн онд бичсэнийг монгол бичгээр бичиж хошууны тамга дардаг байв. Зарим зургууд тамгагүй байх нь ч бий. Монгол бичиг нь хошуу нутгийн зурагтай гайхалтай зохицож яруу сайхны үнэлэмжийг тодруулж, эрхэмсэг болгон орон зайн эзэлхүүн,

агаар алслалттай харагдуулна. Зарим газрын зураг дээр манж, хятад үсгээр бичсэн буй. Хятад манж зураачийн зурсан монголын хошуу нь газрын зургуудад сэтгэл шингээгүй мэт. Мөн зураг дээр дөрвөн зүг, хилийн овоо, замын тухай дэлгэрэнгүй бичсэн байхаас гадна шар улаан цаасан дээр бичиж наасан ч байдаг. Цуглуулагч С.Батбаярт буй Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны газрын зураг нь хонины чанасан ходоодтой төстэй байгаа нь буян хишгийн бэлгэдэл мэт. Хангай нурууны баруун хэсэгт орших ой хөвчит уулс, гол ус, өвс ургамал жигдэрсэн, үхэр мал ихтэй, хүмүн ард нь шашин ном эрдэм ухаанд сүжигтэй, уран дарханы ур бүтээлээрээ алдартай сайхь хошуу нутгийн зураг сонирхолтой. Мөн уул даваа нуур, гол ус тэргүүтэнг зурж монгол бичгээр тайлбарыг нэлээд дэлгэрэнгүй бичиж тойруулсан байна. Цагаан даавуун дээр хар бэхээр зурж нуурын усыг хөхөөр тэмдэглэсэн, хожим буян хишигийг бэлгэдэн тосоор мялааж байснаас зарим хэсэгт нь шар тос нэвчиж, бага зэрэг хир суужээ. Сүсэг бишрэлээс үүдэн өвлийн идэш гаргах, намарцагтөрөмний цагаан тос хольж гүзээнд чихэх үед амны хишиг буянаа дээдэлж өөх тосыг гал, бурхан тахилдаа өргөдөг малчин монголын ёсон буй. Зарим нутгийн газрын зургийг түвэд үсгээр тэмдэглэх нь ч байв. Орхон гол, Ширээ цагаан нуур, Усан зүйлийн орчмын газрын зургийг таталган тэмдэглэж түвэдээр бичсэн нь Өндөр гэгээний минь төрсөн нутаг хэмээн лам хүмүн өөрийн сүжигээр зурж үлдээсэн нь илэрхий. Үүн лүгээ холбон өгүүлэхэд Өндөр гэгээн Занабазарын төрсөн Усан зүйлийн нутгийн газрын шинжийг өгүүлсэн монгол бичгийн дурсгал. Төрж өссөн төрөлх нутгаа нэгд нэгэнгүй мэддэг зөн билигт хүмүн унтах нойр, зүүднийхээ орон зайд нутаг усаа харж зураглан “манаж” байдаг буюу.

Их шүлэгч, ноён хутагт Д.Равжаагийн зохиолд “Монгол газрын жаргал их, молор эрдэнийн тус их” гэсэн нь юутай үнэн. Зөвхөн зурсан зураач, зөвлөн хянасан нутгийн ноёд түшмэд л мэдэх онцгой нууцлал хошуу нутгийн зургуудад төдийгүй авдар, тооно эрээлэх хээ чимэглэл дотор ч бий. Манж, Чин гүрэн Богд хаант Монгол улсын үед дээд газраас ирсэн албан зааврын дагуу үйлдэж байсан зургуудаас гадна зураач, лам нарын сэтгэлээрээ зурж хадгалсан зургууд байдаг. Монголчуудын хошуу нутгийн газрын зургийг харахад шинжлэх ухаан танин мэдэхүйгэхээсээ монгол зургийн задгай дүрслэл, газрын баримжааг хураан агшаасан мэт хэтрүүлэл байгаа ч тэр нь нутгаа мэддэг хүмүүст бол ойлгомжтой. Газрын зураг дээр уул нуруу, гол ус, сүм хийд, овоо тахилга тэмдэглэгдсэн ч харин малчдын өвөлжөө хаваржаа, гэр сууц, гар худаг, мал сүрэг тэмдэглэгдсэн нь ховор юм. Харин байгалийн монгол зурагт бол нутаг орон, хүмүний амьдрал үйл, мал сүрэг, ан амьтдыг ургамал ус үүлтэй нь хамт өргөн дүрслэдэгээрээ ялгаатай байна. “Хүмүн амьтан бүхэн өглөө босоод дэлхийгээ хөхөж амьдардаг, усаа ууж, малаа сааж, сүү шимийг нь хүртэнэ, хүний бие өнгөрөхөд хүүр нь газарт, үйл хэрэг санаа бодол нь үр ач нарт нь, сүнс нь тэнгэрт үлддэг” хэмээн нутгийн лам Шандан гуай өгүүлснээс үзэхүл Монголчууд газар дэлхий, тэнгэр эрхэс, үр удмынхаа тухай гүн ухааны ховор нандин ойлголттой байжээ. Манжийн гүрэн, Богд хаант Монгол Улсын үеийн Халхын хошуу, хойт харуулын нутгийн зургийн баялаг цуглуулга Үндэстний архив, Үндэсний номын санд хадгалагдаж байна. Тэдгээр зургуудыг зурсан арга барил, нутгийн хэмжээ хэлбэр, байгаль уул ус, бичлэгийг харьцуулан үзэж судлах нь манай ард түмний газар зүйн мэдлэг, гоо сайханы ойлголт дүрслэн илэрхийлэх авьяасын онцлогийг тодруулан гаргахад чухал юм. “Монгол газрын зураг хоёр төрөл байна. Тухайлбал хошуу ба бүхэл аймаг (чуулган). Энэхүү газрын зурагт уулсын оргил, гол мөрөн нуур, хилийн цэг засаг ноёны эзэмшил, сүм хийд гэх мэт олон зүйл байна. Гэвч Монголчууд Европ газрын зургийн аргыг мэдэхгүй, тэдэнд масштаб ба тор гэдэг ойлголт үгүй юм” хэмээн Орос, Польшийн эрдэмтэн В.Котвич 1914 онд Монголын газрын зургийн хавсралт, мэдээлэлдээ тэмдэглэжээ. Тэрээр тухайн үед дөнгөж тусгаар тогтноод байсан Богд хаантай Монгол улсын аймаг чуулган, шавь хошуудын газрын зургийн тоймыг гаргаж 1914, 1915 онд ном, сэтгүүлд хэвлүүлсэн нь Баруун Алтай, Ар, Өвөр, Зүүн Монголын ихэнх хошуудын зургийг тойм ерөнхий дүрсэн дурсгал болно. 1915 онд “Для всех знанин” сэтгүүлд Монголын тухай танилцуулгатай сайхь зургийг мөн гаргасан байдаг.


XIX-XX зууны зааг үед Халх Монголчууд дэлхийн бөмбөрцгийн газрын зурагтай танилцсан болов уу? Гэвч үүнээс өмнө хан ноёд, лам хувраг, бадарчин, худалдаачид Ази, Европын орноор худалдаа арилжаа хийж аялан зорчиж орчлонг тойрч явахдаа гадаад улс орны хэвлэмэл газрын зургийг үзэж явсан нь мэдээж. XIII Далай лам Монголд заларсан, 1905 оны Орос-Японы дайны үйл явдал, 1911 онд Манж Чин гүрэн доройтон задарч эхэлсэн зэрэг түүхэн үйл явдлууд Монголчуудын Дэлхий дахины улс төрийн байдлыг сонирхон төр улсаа сэргээх үзэл санаанд нь хүчтэй нөлөөлсөн билээ.

Гадаад их далай хийгээд Европ, Ази, Австрали, Африк тивийг зурж Англи, Франц, Голланд, Португалийн колони эзэмшил газрууд, Манж Чин, Австри-Унгар, Турк, Оросын эзэнт улсуудын нутаг, далайн аралуудыг усан будгаар тодруулан зурж улс орны болон тивүүдийн нэрийг түвэд үсгээр галиглан монгол үгээр бичиж тэмдэглэсэн газрын зураг “Элбэг Арт” галерейд бий. Дэлхийн зүүн бөмбөрцгийн газрын зургийг тогооны амсрын хэмжээтэй тойрог хэлбэрт оруулан зохиомжлон зуржээ. Манж гүрний газрыг шар өнгөөр түүн дотроо Халх Монголын газрыг арай хүнд шараар будаж ялган түвэд үсгээр “Халха” хэмээн бичсэнээс үзэхэд лам хүмүний бүтээл болох нь илэрхий. Мөн Япон, Солонгосын нутгийг шингэн хүрэн ягаанаар зурсан нь XIX-XX зууны зааг үеийн аралын Япон улс өрнөдийн дэмжлэгээр хүчирхэгжин Солонгосын хойгийг эрхэндээ оруулсны хойхно зурсан зураг болно. Зургийн зүүн дээд булан буюу Оросын эзэнт гүрний Алс Дорнод хэсэг нь урагдаж үгүй болсон байдаг. Европ, Америк, Оросоос элч төлөөлөгч, жуулчид, худалдаачдаар дамжин орж ирсэн тэр үеийн дэлхийн улс төрийн газрын зургаас сайхь зургийг хуулж зурсан буй за. Далай хөвөө ирмэг газруудыг хүмүн амьтны гавал ясны заадас мэт нарийн зурсан нь зураачийн хараа хурц, анхааралаа төвлөрүүлэн зүүн бөмбөрцгийн газрын зургийг хуулбарласныг харуулна.

XIX-XX зууны зааг үед зурсан зураач Балганы “Их хүрээ”, Хүрээний их зураач Жүгдэрийн 1913 онд зурсан “Нийслэл хүрээ” зэрэг хүрээ хийдийг зурсан зургууд нь ойр орчимын уулс, гол усны урсгал хөдөлгөөн, газрын зургийн шийдэл, арга ажиллагаа, зохиомжтой зурсан нь газрын зураг зүйтэй холбоотой. Богд хаантай Монгол улс байгуулагдсан 1911 онд хаант Орос улсад Монголчуудын хошуу нутгийн манай улсын газрын зургийг хэвлэх талаар судалгааны ажил хийгдэж байхад Манж Чин гүрний 1912 оны эхээр төр унасны хойно байгуулагдсан Гоминданы Хятадад Монголын олон аймаг хошуудын нутаг дэвсгэрийн зургийг хэвлэн гаргасан байдаг.

Ер нь Монголчуудын эрт үеэс газрын зураг бүтээхдээ тас, бүргэд халих өндөрөөс харсан мэт сэтгэж, арга ухаан, ойлголт танин мэдэхүй нь хүн төрөлхтний газрын зураг зүйн хөгжилд өөрийн гэсэн хувь нэмэрээ оруулсан нь шинжлэх ухааны болоод түүх, урлагийн өв, байгаль дэлхий, амьдралыг хайрлах сэтгэл нь шингэсэн тал бүрийн ач холбогдолтой онцгой дурсгал юм. XX зууны эхээр болон Зөвлөлт улсыг түшиж социализмыг байгуулж байсан Монгол орноор аялсан өрнийн олон аялагч, эрдэмтэд, сэтгүүлчдийн бичсэн тэмдэглэл, түүхийн ном бүтээлүүдэд манай улсын түүхэн газрын зургийг нэлээд хэвлэж байжээ. Энэ нь хоёр их гүрний дунд Монголчууд язгуурын төр улсаа сэргээн байгуулж дэлхий дахинд үлгэр дууриалал болж, үндэс язгуур, эртний түүх, урлагийн өв дурсгал, зан заншил, хэл соёлоо дээдэлж орчин үеийн хөгжил дэвшилтэй дуу хоолойгоо нийлүүлэн яваа нь бидний өвөг дээдсээсээ өвлөсөн эр зориг, тэнгэрийн дохиололыг мэдрэх, эрүүл саруул бүтээлч оюун ухаан, авъяас билиг, ирээдүй хойч үеэ гэх итгэл найдвар, эв эеийг хичээж ирсэн гэм хоргүй нээлтэй цайлган сэтгэлийн үр билээ. Монгол нутгийн газрын зураг зүйн бүтээлүүд, нутаг усны гүн утга учир агуулсан нэршил нь манай өнгөрсөн сүүлийн үеийн түүхийн өв дурсгалан, оюун санаа, орчлонг таниж мэдэхүйн үнэт өв болно.

Харин сүүлийн үед хот хөдөөгүй хэвлэлийн газрууд нэлээд элбэгшсэнээс үүдэн ном бүтээлүүд болон газрын зураг зүйн хэвлэлүүд ямар ч хяналтгүй, үнэн магад нь эргэлзээтэй хэвлэгдэж буйд хаа хаанаа анхаарах цаг болжээ.



Ном зүй

1. Бадрал С. “Хүннү дээдсээс илгээсэн ширдэг” “Ил товчоо” №12, 1995
2. Бадрал С. “Өлзий хээ Монголын бэлгэдэл” “Ил товчоо” №41, 1997
3. Бадрал С. “Хэнгэрэг дээрх ертөнц” “Улаанбаатар таймс” №102-106, 1999
4. Бадрал С. “Дундад Ази, Алтай Ордоны Монголчуудын дунд 30 жил суусан гарамгай цэрэг”, “Ил товчоо” №14, 1999.
5. Бадрал С. “Монгол зургийн засвар хийж байсан уламжлалаас эргэцүүлэхүй” Улаанбаатар таймс №66. 2002.
6. Бадрал С. Чингис хааны өв соёл музейд буй хуучин торгууд хошууны нутгийн газрын зураг. Чингис хаан судлал УБ. 2009 №12. х120-121
7. Бадрал С. “Монголын хөдөө л монгол үндэстний амин сүнс буй” Урлагийн ертөнц, Урлагийн ертөнц, х3-5. УБ. 2014
8. Бадрал С. “Хонгор нутгийн Баянговь минү” Улаанбаатар таймс. №40, 2003
9. Бадрал С. “Сэтгэлийн тэнгэр-Их Богд уул минү!” Хөдөлмөр. №38, 1996
10. Бадрал С. “Үлгэрийн гайхамшигт Баянговь минү!” УБ таймс №135, 2006
11. Бадрал С. “Нийслэл хотын шав тавьсан газрын зураг” УБ таймс №125. 2002
12. Бадрал С. “Чингис хаан монгол түүх урлагийн өв дурсгал” УБ. 2011
13. Котвич В. “Монголын түүхийн хураангуй тэмдэглэл ба түүний эдүгээгийн улс төрийн байдал” УБ. 2011.
14. Нарантуяа Ч. “Монгол дахь монгол гар бичмэл судрын гарчиг” УБ. 2008.
15. Шагдарсүрэн Ц. “Монголчуудын утга соёлын товчоон” УБ. 2003.
16. Салищев К.А. “Картоведение” М. 1990
17. “Чингис хаан ба түүний залгамжлагчид, Монголын дэлхийн эзэнт гүрэн” Берлин, 2010.
18. “Газрын шинжийн Монгол судар” УБ. 2012.
19. “Иллюстрированнаяэнциклопедиягеография” Минск. 2002.
20. “Impressions of the East” California. 2007.

SUMMURY

A landscape relief map made of clay, which is the most ancient mapping monument, was found in ancient Vavilon archeological findings and an ancient Greek historian Gerodot recorded about Euro-Asian continents, oceans and tribes whereas a scientist Erastosfen did exploration by using the geographic formation of the globe in mathematics calculation. Likewise, during Roman Empire the maps of the states around the Mediterranean, Europe and the Middle East were created and used for army, politics, trade and transportation.

Mongolian traditional historic heritages as cultural monuments, arts, traditions, rites, religions, and herding have attracted researchers' attention all the time and have been mentioned and expressed in their works much or less. Among them, mapping monuments of Mongolian nature have been explored since 1941 and some works on the field have been published. There are quite many ancient sources of Mongolian mapping. Typically, Mongolians created geographical maps so well that they could see their lands and territories from the sky and contributed to the development of human cognition and geographic mapping.

Considerable number of maps of historic geography of our country has been published in the notes and history books by the western tourists, scholars and journalists who travelled through our country at the beginning of XX century and in socialist period in mid XX century.

Cartographic works of Mongolian territory and deep-meant naming of its places are inevitably the heritage from our ancestors for recognizing our past and present history and culture.

Nevertheless, we should pay close attention to the modern works and maps that are being published without any controls and supervision.